

Аймгийн ХХААЖДҮГазар:

Аймгийн ХХААЖДҮГазар нь бодлого зохицуулалт, мал эмнэлэг, малын үржлийн алба гэсэн 3 албатай 25 орон тоотой үйл ажиллагаа явуулж, мал аж ахуй, газар тариалан, хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилготой ажиллаж байна.

Сумдад мал эмнэлэг, үржлийн тасаг 3 орон тоотой үйл ажиллагаа явуулж, 17 суманд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх 49 аж ахуй нэгж ажиллаж байна.

1. Мал аж ахуйн үйлчилгээний талаар:

- Малын үүлдэр угсааг сайжруулах зорилгоор бүх төрлийн малд үзлэг ангилалт хийж, заавар, зөвлөмж өгөх
- Малчид, аж ахуйн нэгжийн саналын дагуу нэн ялангуяа үхэрт зохиомол хээлтүүлэг хийх
- Бэлчээрийн хортон шавьжтай тэмцэх, худаг ус гаргаж бэлчээрийн усан хангамжийг жил бүр нэмэгдүүлэх
- Малын хээл тодорхойлох ажил үйлчилгээ хийх
- Шилмэл хээлтүүлэгчийг шинээр сонгон тавих, мал хээлтүүлгийн ажлыг зохион байгуулж, мэргэжлийн зөвлөгөө өгөх, хяналт тавих
- Үржлийн малд ашиг шим, удам гарвалын бүртгэл хөтлөх
- Малын тарга хүчийг тодорхойлох
- Мал маллагааны технологи боловсруулах
- Жил бүр улс, аймгийн тэргүүний малчин, малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл шалгаруулна.

2. Мал эмнэлэгийн ажил үйлчилгээний талаар:

- Мал, амьтанд эрүүл мэндийн үзлэг хийх
- Мал, амьтанд эмнэлзүйн үзлэг хийх
- Лабораторийн болон харшил, сорилын шинжилгээ хийх
- Мал, амьтанд тарилга хийх
- Нян, ийлдэс, шимэгч судлалын шинжилгээ хийж, эмчлэн сэргийлэх
- Мал эмнэлэгийн ариун цэврийн магадлан шинжилгээ хийх
- Өвс, тэжээлийн дээжинд хор судлалын шинжилгээ хийх
- Мал эмнэлэгийн ариутгал, халдваргүйжүүлэлт хийх
- Мал, амьтанд мэс ажилбар ба эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлэх
- Малд халдварт, паразит, халдваргүй өвчнөөс эмчлэн сэргийлэх, тэмцэх заавар зөвлөмж өгөх

3.Газар тариалангийн үйлдвэрлэл:

- Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
- Танхимын болон талбайн үзүүлэх сургалтуудыг зохион байгуулах
- Үр, бордоо, ургамал хамгааллын бодис, жимс, жимсгэний суулгац, хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй үнээр болон лизингээр нийлүүлнэ.
- Жил бүр улс, аймгийн тэргүүний тариаланч, тариаланчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл шалгаруулна.

4.Хоршооны талаар:

- Хоршоо байгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.
- Хоршоо байгуулахад бүрдүүлэх материал, гарын авлагаар хангах
- Хоршоог бэхжүүлэх, чадавхижуулах, хоршооны дарга, менежер нарт зориулсан сургалт өгөх, холбогдох бусад мэдээллээр хангана.
- Хоршоог төрийн зүгээс дэмжиж, төсөл хөтөлбөрт хамруулах
- Хоршооны гишүүн малчинд хонь, тэмээний ноос, арьс, ширний урамшуулал олгох

Эдгээр үйлчилгээ авахад дараах материал бүрдүүлнэ.

- Тухайн багийн малчдын санал, иргэдийн нийтийн хурлын шийдвэр, сумын санал байж болно.
- Аймгийн ИТХ-ын 2011 оны 39 тоот тогтоолоор батлагдсан Мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний үнэлгээний тарифыг мөрдөнө.
- Малчид, иргэдийн өргөдөл, хүсэлт
- Халдварт өвчинтэй тэмцэх, эмчлэн сэргийлэх талаар сумын мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг Аймгийн ХХААЖДҮГ азрын мал эмнэлэгийн албанд жил бүр ирүүлнэ.
- Хонь, тэмээний ноосны урамшуулал олгох журмын дагуу малчид холбогдох материалыг бүрдүүлэн сумын мал эмнэлэг, үржлийн тасагт 8 сарын 30-ны дотор материалаа өгсөн байна.

Ховд аймгийн ХХААЖДҮГ